

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.02 № 14

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллага, ард иргэдэд сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл суртчилгаа хийжээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 14,014.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 6,547.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 9,380.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 100.0 хувиар бүрэн хэрэгжүүлэн тайлагнасан бөгөөд Улсын Ерөнхий Прокурорын газраас тайланг үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

. 07020981

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,832.7	30,318.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	643,205.2	619,008.8
Нийт хөрөнгийн дүн	669,037.9	649,326.9
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	669,037.9	649,326.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	669,037.9	649,326.9
Үйл ажиллагааны орлогын дүн	650,908.0	671,974.1
Үйл ажиллагааны зардлын дүн	626,949.6	718,055.1
Үйл ажиллагааны үр дүн	23,958.3	(46,081.0)
Үйл ажиллагааны бус үр дүн	8,500.0	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	15,458.3	(46,081.0)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	650,192.3	669,037.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(242.8)	26,370.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,630.0	-
Тайлант оны үр дүн	15,458.3	(46,081.0)
Эцсийн үлдэгдэл	669,037.9	649,326.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	578,901.6	665,426.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	566,731.6	651,412.7
Үйл ажиллагааны ЦМГ	12,170.0	14,014.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(12,170.0)	(14,014.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	476,716.0	626,466.4
Урсгал зардал	464,546.0	612,452.4
Хөрөнгийн зардал	12,170.0	14,014.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	476,716.0	626,466.4
Улсын төсвөөс санхүүжих	476,716.0	626,466.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 31,502.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайлангийн зардлыг 4,127.5 мянган төгрөгийг зөрүүтэй, бичиг хэргийн материалын орлого, зарлагыг 1,005.2 мянган төгрөгөөр дутуу, бичиг хэргийн материалын орлого, зарлагыг 1,005.2 мянган төгрөгөөр дутуу, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 1500 м.кв талбай газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ талбайн үнэлгээг буруу тооцож 26,370.0 мянган төгрөгөөр дутуу үнэлж тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 2,287.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,287.4 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 2,107.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөрчил арилгуулах, давтан гаргахгүй албан шаардлага, 180.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2,107.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Бараа үйлчилгээний бусад зардал: Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа үйлчилгээнд төлөх зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бичиг хэргийн материалын зарлагын баримтыг түүвэрлэн шалгахад 180.0 мянган төгрөгийн бичгийн цаасыг шаардах хуудасгүй зарлагадсан байгаа нь Нягтлан бодох

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.
нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримтыг үндэслэн зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	/Мянган төгрөгөөр/											
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 4,127.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.		1	4,127.5			1	4,127.50	1	4,127.50	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Прокурорын газар	Бичиг хэргийн материалын орлого, зарлагыг 1,005.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	1,005.2			1	1,005.2	1	1,005.20	-	-	-	-
	Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 1500 м.кв талбай газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ талбайн үнэлгээг буруу тооцож 26,370.0 мянган төгрөгөөр дутуу үнэлж тайлагнасан.	1	26,370.0			1	26,370.0	1	26,370.0				
Дүн		3	31,502.7			3	31,502.7	3	31,502.7	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	/Мянган төгрөгөөр/											
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Говь-Алтай аймгийн Прокурорын газар	Бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2,107.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.	1	2,107.4	-	-	1	2,107.4	-	-	-	-	-	
	Бичиг хэргийн материалын зарлагын баримтыг түүвэрлэн шалгахад 180.0 мянган төгрөгийн бичгийн цаасыг шаардах хуудасгүй зарлагдсан байна.	1	180.0	-	-	-	-	1	180.0	-	-	-	
		2	2,287.4	-	-	1	2,107.4	1	180.0	1	180.0	-	-